



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/388

Булган сум

### Гүржлийн малд үзлэг ангилалт хийж, малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Малын генетик нөөцийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.8.6, 18 дугаар зүйлийн 18.2.2, 18.2.3 дахь хэсэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/136 дугаар “Гүржлийн малд үзлэг, ангилалт хийж, малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох ажлын төсвийн хуваарь батлах тухай” тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баталгаажсан үүлдэр, омгийн бог малын хээлтүүлэгчид үзлэг ангилалт хийх, баталгаажуулах, ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх ажлыг 2024 оны 05 дугаар сарын 28-наас 11 дүгээр сарын 01-ийг хүртэл зохион байгуулсугай.

2.Мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, явцын хяналт тавих, үр дүнг тайлагнах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Ч.Амгалан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)  
Гишүүн: Ц.Бямбацогт (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн хяналтын улсын байцаагч)  
А.Ганхуяг (Хүнс, хөдөө аж ахуйн газрын МҮА-ны мэргэжилтэн)  
Д.Сэрчлхам (Хүнс, хөдөө аж ахуйн газрын МҮА-ны мэргэжилтэн)  
Нарийн бичгийн дарга: М.Жавзандолгор (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны дарга)

3.Уг ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг холбогдох сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Баталгаажсан үүлдэр, омгийн бог малын хээлтүүлэгчид үзлэг ангилалт хийх, баталгаажуулах, ялган тэмдэглэж бүртгэлжүүлэлт хийсэн ажлын явцад хяналт тавьж ажиллахыг ажлын хэсэг (Ч.Амгалан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ



Sugar Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Засахирамж

6324010510